БАТЛАВ.
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
..... Ш.БАТБАЯР

2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр

“ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ, ОРОЛЦООГ ТАНДАХ САНАЛ АСУУЛГА ЯВУУЛЖ, БИОАЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦООНД ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ЦАХИМ ПЛАТФОРМ БИЙ БОЛГОХ” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хот

1	**Үндэслэл**	Монгол Улс Биологийн олон янз байдлын тухай конвенцын Биоаюулгүй байдлын тухай Картагений протоколд 2002 онд нэгдсэн бөгөөд одоогоор дэлхийн 173 улс тал болжээ. 2007 онд нэгдэн орсон олон улсын эрхзүйн баримтын хүрээнд Хувиргасан амьд организмын тухай хуулийг УИХ-аас соёрхон батлсан бөгөөд энэ төрлийн эрхзүйн баримттай цөөн орны нэг юм. Энэхүү хуулийн дагуу Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хороог байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд төр, хувийн хэвшил, мэргэжлийн төрийн бус байгууллага, судалгааны байгууллагын төлөөлөл гэсэн олон талын оролцоотой байгуулж, гол төлөв олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, тусламжаар энэ чиглэлийн үйл ажиллагаа, чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн. Манай оронд биоаюулгүй байдлын талаар оролцогч талуудын болон олон нийтийн ойлголт мэдээлэл бага, энэ талын эрсдэлийн үнэлгээ хийх, бүртгэлжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг бодлогын зохицуулалт, хэрэгжилтийн ажил учир дутагдалтай хийгдэж ирсэн. Энэхүү байдлыг даван туулахад олон улсын хамтын ажиллагаа, туршлага, дэмжлэг чухал үүрэгтэй байсан бөгөөд цаашид ч энэхүү үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх шаардлагатай. НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Даян дэлхийн байгаль орчны сангийн дэмжлэгтэйгээр Монгол, Филиппин, Энэтхэг, Бангладеш зэрэг 4 орны хамтарсан “*Ази тивд биоаюулгүй байдлын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд биотехнологийн аюулгүй хэрэглээг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд дэмжих нь*” төслийг БНСУ-ын Биоаюулгүй байдлын хамтын ажиллагааг дэмжих хүрээлэн (KIPABiC)-гийн удирдлага, менежментийн хүрээнд хэрэгжүүлж эхлээд байна. Төсөл дараах үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй:

		1. Биоаюулгүй байдлын олон талт, олон улсын хамтын ажиллагааг дэмжих; 2. Үндэсний хэмжээнд биоаюулгүй байдлын тогтолцоог бий болгох, цаашдын хөгжил, үр дүнтэй хэрэгжилтийг хангах; 3. Мэдээлэл солилцох, мэдлэгийн менежмент, боловсрол, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоог бий болгох; 4. Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. Тус төслийн хүрээнд Биологийн олон янз байдалд нөлөөлөх хувиргасан амьд организмын болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалагдсан байх тухайлбал, төсөл хэрэгжүүлж буй орнуудын байгууллагын болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн оролцоо, мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдлэгийн менежментийг сайжруулах, улс орнуудын тогтвортой харилцаа холбоо/сүлжээ үүсгэх үйл ажиллагаа хэрэгжиж, шилдэг туршлага, сургамжаар улс хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлсэн байна.
2	Зорилго	1. Биоаюулгүй байдлын талаар үнэн зөв, баталгаат мэдээллийн хүртээмж, олон нийтийн мэдлэг, мэдээлэл, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх үйл ажиллагааг томьёолох, алдаа дутагдал, хийдлийг тодорхойлох судалгаа/санал асуулга зохион байгуулах. 2. Олон нийтийн боловсрол, мэдлэг, оролцоо болон биоаюулгүй байдлын мэдээллийн хүртээмж, нээлттэй байдлын тогтолцоонд үнэлгээ хийж, баримтжуулан, үр дүнтэй тогтолцоог бий болгох, зөвлөмж боловсруулах (road map-замын зураглал), хэрэгжилтийн төлөвлөгөө бий болгох. 3. Биоаюулгүйн зуучлагч механизм вебсайтыг шинээр хөгжүүлж, хүлээлгэн өгөх.
3	Ажил гүйцэтгэх хугацаа	Ажлыг гэрээ байгуулсан өдрөөс хойш 60 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
4	Гүйцэтгэх ажил	1. Биоаюулгүй байдлын талаарх эрх зүйн орчин, шийдвэр гаргах шат дамжлаг, авч хэрэгжүүлж буй ажлуудын талаар үнэн зөв, баталгаат мэдээллийн хүртээмж, олон нийтийн мэдлэг мэдээлэл, оролцоог сайжруулахад хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа, алдаа, хийдлийг тодорхойлох судалгаа/санал асуулгыг мэргэжлийн хүрээнд болон олон нийтийн гэсэн 2 үе шаттайгаар хүлээн зөвшөөрөгдсөн зохих арга зүй, стандартын дагуу зохион байгуулах; 2. Монгол Улсын хэмжээнд биоаюулгүй байдлын талаарх мэдээллийн хүртээмж, чанар, ил тод байдал, олон нийтийн боловсрол, мэдлэг, оролцоонд үнэлгээ хийх; 3. Олон нийтийн боловсрол, мэдлэг, оролцоо болон биоаюулгүй байдлын мэдээллийн хүртээмж, нээлттэй байдлыг сайжруулах чиглэлд ямар үр дүнтэй бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой талаар 10-аас

		доошгүй үндсэн үйл ажиллагааны саналыг авч хэрэгжүүлэх 3 жилийн төлөвлөгөөг боловсруулсан байна. Жишээ нь олон нийтийн телевиз, нийгмийн сүлжээ эсвэл боловсролын сургалтын хөтөлбөрүүдэд нэмэлт өөрчлөлт хийх гэх мэт. Монгол Улсын биоаюулгүй байдлын нөхцөл байдлын талаар 3-аас доошгүй шторк (1-2 мин), видео, олон нийтэд ойлгомжтой 1 ш. гарын авлага боловсруулах. 4. Биоаюулгүйн зуучлагч механизм вебсайтыг төслийн хамтрагч орнууд болон үндсэн биоаюулгүйн зуучлагч механизмтай /https://bch.cbd.int/ уялдаатай, хоорондын мэдээллийн холбогдох линкүүдийг холбосон, олон нийтэд ойлгомжтой хүртээмжтэйгээр вебсайт хөгжүүлж, шаардлагатай анхан шатны мэдээллийг оруулж баяжуулах; 5. Олон улсын болон төслийн түнш орнуудын олон нийтийн боловсрол, мэдлэг, оролцоо болон биоаюулгүй байдлын мэдээллийн хүртээмж, нээлттэй байдлын 2-оос доошгүй шилдэг жишээ, туршлагыг нэвтрүүлэх; 6. Төр болон хувийн хэвшлийн салбараас тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжигч, биоаюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголт сайтай манлайлагчийг (улс төрч, нийгмийн зүтгэлтэн, бизнесмен) тодорхойлж, тухайн төлөөлөлтэй тохиролцсон байна; 7. Дээрх тайлан, судалгааны ажлын хураангуй танилцуулга, илтгэл мэдээллийг бэлтгэх /PPT, инфографик бэлтгэсэн байна./; 8. Тайлантай холбоотой хэлэлцүүлгийг талуудад зохион байгуулах, санал дүгнэлтийг тусгасан тайлан.
5	Тайлагналт	Эхлэлийн тайлан: Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас 10 хоногийн дотор гэрээт ажлын хүрээнд календарчилсан төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөсөн судалгааны арга зүйг танилцуулж захиалагчтай нэгдсэн байр суурьтай болсон байна. Явцын тайлан: Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас 30 хоногийн дотор судалгааны тайлан болон ажлын явцын тайланг боловсруулж танилцуулсан байна. Эцсийн тайлан: Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас 60 хоногийн дотор эцсийн тайланг гэрээ байгуулагч талд ирүүлсэн байна.
6	Ажил гүйцэтгэгчид тавигдах шаардлага	Зөвлөх үйлчилгээний баг нь 4-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх ба байгаль орчин, хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээр сургалт, олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулах ажил гүйцэтгэж байсан туршлагатай баг байна. <u>*Байгууллагад тавигдах шаардлага:*</u> • Ажил гүйцэтгэх байгууллага нь 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай хуулийн этгээд байх;

		• Олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, оролцогч талуудыг тодорхойлох чиглэлээр ажилладаг, ижил төстэй зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай бол давуу тал болно. *Зөвлөх үйлчилгээний багт тавигдах шаардлага:* Багийн бүрэлдэхүүнд дараах мэргэжилтнүүд байна. Үүнд: - Багийн ахлагч, нийгэм хүмүүнлэгийн ухааны, байгаль орчны болон зөвлөх үйлчилгээтэй холбогдох салбарын мэргэжилтэн, судлаач; - Байгаль орчин болон бусад салбарын эрх зүй, засаглал, олон нийттэй харилцах чиглэлээр ажиллаж байсан, оролцогч талуудын оролцоог тодорхойлох, SWOT шинжилгээ хийх, талуудтай зөвлөлдөх болон тэдний оролцоог хангах төлөвлөгөө боловсруулах зэрэг чиглэлүүдээр ажиллаж байсан туршлагатай байх; - Биологич, биотехнологийн чиглэлийн мэргэжилтэнтэй байх; - Вебсайт хөгжүүлэх чадвартай, PHP, MySql программын хэлний зохих ёсны мэдлэгтэй ажилтантай эсвэл мэргэжлийн байгууллагатай түншлэл хэлбэрээр гэрээлсэн байх. • Багийн ахлагч болон гишүүд нь мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх; • Англи, Монгол хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх; • Тайлантай холбоотой инфографик, илтгэл мэдээлэл бэлтгэх чадвартай байх; • Харилцааны өндөр мэдлэгтэй, захиалагч талтай хамтран ажиллаж, ойлголцох ур чадвартай байх.
7	Захиалагч байгууллага	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
8	Хүрэх үр дүн	• Биоаюулгүй байдлын талаарх эрх зүйн орчин, шийдвэр гаргах шат дамжлаг, авч хэрэгжүүлж буй ажлуудын талаар үнэн зөв, баталгаат мэдээллээр хангах, мэдээллийн хүртээмж, олон нийтийн мэдлэг мэдээлэл, оролцоог сайжруулахад хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа, алдаа, хийдлийг тодорхойлох судалгаа/санал асуулгыг зохион байгуулсан байна. • Биоаюулгүй байдлын талаарх олон нийтийн мэдлэг, боловсрол, оролцооны чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж 1-ээс доошгүй хэлэлцүүлгийг зохион байгуулж, холбогдох саналыг авах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3 жилийн төлөвлөгөөг боловсруулж, эрэмбэлсэн эцсийн тайланг боловсруулах. • Олон нийтийн боловсрол, мэдлэг, оролцоо болон биоаюулгүй байдлын мэдээллийн хүртээмж, нээлттэй

		байдлын тогтолцооны үнэлгээний тайланг 1-ээс доошгүй удаа хэлэлцүүлсэн байх. • Биоаюулгүйн зуучлагч вэбсайтыг хөгжүүлж, мэдээллээр баяжуулсан байна. • Монгол Улсын биоаюулгүй байдлын нөхцөл байдлын талаар 3-аас доошгүй шторк (1-2 мин), видео, олон нийтэд ойлгомжтой гарын авлага, 1 ширхэг брошур боловсруулсан байна. • Олон улсын болон төслийн түнш орнуудын олон нийтийн боловсрол, мэдлэг, оролцоо болон биоаюулгүй байдлын мэдээллийн хүртээмж, нээлттэй байдлын хангахад чиглэсэн 2-оос доошгүй жишээ, туршлагыг нэвтрүүлсэн байна. • Биоаюулгүй байдлыг дэмжигч боломжит манлайлагчийг (улс төрч, нийгмийн зүтгэлтэн) тодорхойлж, санал болгосон байна.
9	Хүлээн авах материал	• Биоаюулгүй байдлын чиглэлийн үнэн зөв, баталгаат мэдээлэл хүртээмжтэй байдаг эсэх, энэ чиглэлд олон нийтийн мэдлэг мэдээлэл, оролцоог сайжруулахад хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа, алдаа, хийдлийг тодорхойлох судалгаа/санал асуулга болон одоо байгаа тогтолцооны үнэлгээний тайлан, тайлангуудын үр дүнгийн товч инфографик; • Биоаюулгүй байдлын талаарх олон нийтийн мэдлэг, боловсрол, оролцооны чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны 3 жилийн төлөвлөгөө; • Хавсралт 1-т заасан үзүүлэлт бүхий Биоаюулгүйн зуучлагч вэбсайт бэлэн болсон; • Биоаюулгүй байдлын нөхцөл байдлын талаар 3-аас доошгүй шторк, олон нийтэд ойлгомжтой гарын авлага, брошюр боловсруулсан байна; • Олон улсын болон төслийн түнш орнуудын олон нийтийн боловсрол, мэдлэг, оролцоо болон биоаюулгүй байдлын мэдээллийн хүртээмж, нээлттэй байдлын хангахад чиглэсэн 2-оос доошгүй жишээ, туршлагыг нэвтрүүлсэн байна. Холбогдох хууль тогтоомжийн арга, аргачлалын дагуу хийсэн тайланг монгол болон англи хэл дээр хүлээж авна. Тайлантай холбоотой илтгэл, инфографик, хураангуй танилцуулгыг мөн монгол, англи хэл дээр хүлээн авна.
10	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Даян дэлхийн байгаль орчны сангийн санхүүжилттэй “*Ази тивд биоаюулгүй байдлын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд биотехнологийн аюулгүй хэрэглээг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд дэмжих нь*” төсөл
11	Санхүүжилт	Энэхүү ажлыг гүйцэтгэх зардал 51,000,000 (Тавин нэгэн сая) төгрөг болно. Үүнд ажил гүйцэтгэгчийн ажлын хөлс, ногдож болох аливаа татвар, хураамж, шимтгэл бүгд багтана.

“БИОАЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦООНД ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ЦАХИМ ПЛАТФОРМ БИЙ БОЛГОХ, ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ, МЭДЛЭГ, ОРОЛЦООГ ТАНДАХ САНАЛ АСУУЛГА” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВРЫН НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

№	Үзүүлэлт	Шаардлага
1	Үндсэн вэсбайтын загвар	Биоаюулгүйн зуучлагчийн Үндсэн вэбсайтын загварыг дагах (https://bch.cbd.int/en/)
2	Вэб сайтын хамгаалалт болон аюулгүй байдал	Хэрэглэгчийн нэвтрэх эрхийн хяналт: админ, Модератор түвшний эрх, дүрийн тохиргоотой байх Мэдээлэл шифрлэх: HTTPS protocol ашиглах (SSL certificate) Аудит лог: Системийн үйл ажиллагаа бүрийг бүртгэж хадгалах
3	Сайт	Динамик (Front-End технологи: NextJS (эсвэл ижил төстэй Javascript framework ашиглах); Back-End технологи: Node.js; Өгөгдлийн сан: MongoDB
4	Вэб удирдлагын системтэй байх	- Мэдээлэл шинээр оруулах, засварлах, админ хэрэглэгчийн эрхийн тохиргоо гэх вэбсайтыг бүрэн удирдах боломжтой байх - CMS -н боломжийг хангасан байх
5	Mobile responsive	Бүх төрлийн гар утас болон таблет дээр хэвийн ажилладаг байх. вэбсайтыг компьютероос гадна жижиг дэлгэцтэй төхөөрөмжүүд болох таблет, мобайл төхөөрөмжид харуулах зорилгоор хүрээ хэрэглэлгүй CSS хэрэглэсэн байх хэрэгтэй.
6	Google SEO	Хайлтын системийн тохиргоо хийгдсэн байх, мөн google analytic ашигласан байх
7	Banner management	Баннерыг удирдах боломжтой байх.
8	Content management	Зураг, текст, видео контент оруулах өөрчлөх боломжтой байх
9	Search module /related & tagged /	Хайлтын модуль: ижил төстэй утгаар, түлхүүр үгээр. Хандалт хийхэд хурдан дуудагддаг байх шийдлийг сонгосон байх;
10	Мэдээлэл баяжуулах	Мэдээ мэдээллүүдийг оруулахдаа олон төрлийн форматаар текст, pdf, jpeg, видео гэх мэт форматаар оруулах боломжтой байх
13	Вебсайт 2 жилийн баталгаат хугацаатай байна	Баталгаат хугацаанд шаардлагатай засвар үйлчилгээ, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийж өгнө.
14	Хэлний сонголт:	Монгол, англи хэлний сонголттой
15	Жишиг вэбсайтны загвар	https://bch.cbd.int/en/ http://geacindia.gov.in/india-bch.aspx; https://bch.dost.gov.ph/